

Хуулийн зорилт

- Төсвийг үр ашигтай захиран зарцуулах
- Ил тод, нээлттэй үйл ажиллагаа
- Олон нийтийн хяналтыг бий болгох боломжоор хангах

Хуульд хамаарах төсөв, санхүүгийн үйл ажиллагаа

- Улс, орон нутгийн төсөв, НДС болон ХХС
- Орон нутгийн хөгжлийн сан, Засгийн газрын тусгай сангууд, төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа
- Засгийн газар, орон нутгийн өрийн бичиг, санхүүгийн бусад хэрэгсэл, баталгаа зэрэг төсвийн өр, авлага үүсгэсэн аливаа үйл ажиллагаа
- Засгийн газар, орон нутгийн гадаад болон дотоод зээл буцалтгүй тусламж
- Төр хувийн хэвшлийн түншлэл, концесс

Шилэн дансны зарчим

- Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх
- Мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх
- Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх
- Хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад мэдээлэл нээлттэй байх

Шилэн дансны мэдээлэл хүргэх хэлбэр

- Тухайн байгууллагын цахим хуудсаар /шилэн дансны бие даасан цэстэй байх/
- мэдээлэл татаж авах, хэвлэх боломжтой байх
- тодруулга өгөх албан тушаалтны нэр, утас, цахим хаяг
- цахим хуудасны архивт хадгалах, архивын мэдээллийн санд нэвтрэх, татаж авах, хэвлэх боломжтой байх
- Дуу болон дүрс бичлэгийн хэлбэрээр байршуулж болно
- Мэдээллийн самбар
- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар

Мэдээлэл байршуулах хугацаа /нийт 37 мэдээлэл/

Жилд нэг удаа /8 төрөл/

Тухайн жилийн төсөв

/1 дүгээр сарын 10-ний дотор/

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө /төсөв/

/1 дүгээр сарын 10-ны дотор/

ОНХС-н төлөвлөлт

/1 дүгээр сарын 10-ны дотор/

Жилийн эцсийн нэгдсэн төсвийн үзүүлэлт

/1 дүгээр сарын 15-ны дотор/

Жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт

/4 дүгээр сарын 25-ны дотор/

Жилийн төсвийн гүйцэтгэл

/4 дүгээр сарын 25-ны дотор/

Аудитын дүгнэлтэд туссан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

/7 дугаар сарын 01-ны дотор/

Төсвийн төсөл

/9 дүгээр сарын 15-ны дотор/

Нэгдсэн төсвийн гүйцэтгэл ЗГНСТайлан

/8 дугаар сарын 25-ны дотор/

Хагас жил тутам /3 төрөл/

Хагас жилийн төсвийн гүйцэтгэл

/8 дугаар сарын 15-ны дотор/

Хагас жилийн санхүүгийн тайлан

/8 дугаар сарын 15-ны дотор/

Хагас жилийн Нэгдсэн төсвийн үзүүлэлт

/7 дугаар сарын 15-ны дотор/

Улирал, сар тутам /11 төрөл/, 7 хоногийн дотор /9 төрөл/

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ

/сар бүрийн 8-ны дотор/

Төсвийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбар

/улирал бүр/

10 сая төгрөгөөс дээш ХА-ын талаарх мэдээлэл

/улирал бүр/

- Байгууллагын төсөв, орон тоо, төлбөр хураамжид орсон өөрчлөлт
- тендер шалгаруулсан тухай мэдээлэл
- 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт
- Цалингаас бусад сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээ
- худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын дүгнэлт бусад хяналт шалгалтын тайлан
- Өмч хөрөнгө, өр авлага үүсгэсэн мөнгө зарцуулсан шийлвэр

Мэдээлэл байршуулах албан тушаалтан

- Шийдвэр гаргаж, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан
- Эрх бүхий албан тушаалтан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь хөндлөнгөөс нөлөөлсөн албан тушаалтан
- Тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан

Хяналт, хариуцлага

Хяналт:

Хөндлөнгийн хяналт

- Иргэн, хуулийн этгээд
- Бүх шатны ИТХ, иргэдийн нийтийн хурал
- Төрийн аудитын байгууллага

Дотоод хяналт

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын алба

Хариуцлага:

- Төрийн албан тушаалтанд /Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан сахилгын шийтгэл/
- Бусад албан тушаалтанд /Шүүх, эрх бүхий улсын байцаагч тогтоосон бол нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50-100 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно/

ШИЛЭН ДАНСНЫ СИСТЕМИЙН ХЭРЭГЛЭГЧ

1. НЭГДСЭН АДМИН /Сангийн яам/

ШД-ны журмын 7 зугаар зүйлийн 7.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- ШД нэгдсэн цахим хуудасны үндсэн тохиргоог хийх
- ШДТХ-ийн 1.2-т заасан байгууллагыг ШД-ны нэгдсэн цахим хуудсанд бүртгэх
- ШДТХ-ийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтан мэдээлэх мэдээллийн төрөл, хугацааг тохируулах
- Байгууллага бүрт нэг байгууллагын админ хэрэглэгч үүсгэх

2. БАЙГУУЛЛАГЫН АДМИН

ШД-ны журмын 7 дугаар зүйлийн 7.3-т заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Байгууллагын мэдээлэл оруулах хэрэглэгчийн эрхийг үүсгэх
- ТЕЗ-ийн админ нь харъяа байгууллагын жагсаалт болон хэрэглэгчдийн мэдээллийг хянах мөн хэрэглэгчдийн нэвтрэх нэрийг харъяа байгууллагуудад мэдээлэх
- Байгууллагын улирлын тайланг харъяа дээд шатны байгууллагад илгээх

3. БАЙГУУЛЛАГЫН ХЭРЭГЛЭГЧ

ШД-ны журмын 7 дугаар зүйлийн 7.4-т заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Байгууллагын админ хэрэглэгчээс олгосон эрхийн дагуу холбогдох мэдээллийг ШДТХ болон журамд заасан хугацаанд оруулж баталгаажуулах
- Мэдээлэл шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд үнэн зөв тавигдсан эсэхийг шалгах
- Бусад төсөв, санхүүгийн системээс мэдээлэл татсан тохиолдолд тухайн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд тавихаас өмнө үнэн зөв эсэхийг сайтар нягтлах

4. АУДИТ /Зөвхөн ТТЗ, ТЕЗ-ийн дотоод аудитын нэгж хариуцна/

ТТЗ болон ТЕЗ-ийн аудит нь:

- Харъяа байгууллагын илгээсэн тайланг нэгтгэж харах
- Тайлан ирүүлээгүй байгууллагад хяналт тавих
- Ирүүлсэн байгууллагын тайланг мэдээлэл тус бүрээр задалж харах, шалгах
- ШД-ны мэдээллийг хугацаа хоцроосон, буруу, дутуу мэдээлсэн байгууллагад шаардлага тавих

5. ХӨНДЛӨНГИЙН АУДИТ /Сангийн яам, Үндэсний аудитын газар/

- Улсын хэмжээнд бүх ТЕЗ нарын шилэн дансны тайланг нэгтгэж харах
- ТЕЗ-ийн харъяа байгууллагын мэдээллийг дотогш нь задалж харах
- ШД-ны мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн гүйцэт мэдээлээгүй ТЕЗ-д шаардлага тавих
- Улсын хэмжээний ШДТХ хэрэгжилтийн тайланг нэгтгэх

Бүх байгууллага тус бүрт “**Байгууллагын хэрэглэгч**” (тухайн байгууллагын мэдээлэл байршуулж буй ажилтан) ба “**Байгууллагын админ**” гэсэн 2 төрлийн эрх олгосон байгаа бөгөөд “**Байгууллагын админ**” эрхээр шилэн дансны нэгдсэн цахим системд (<http://info.shilendans.gov.mn/login>) нэвтэрч орно.

Төрийн нууц, үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон үйл ажиллагаа хамаарахгүй.

Өвөрхангай аймгийн засаг даргын дэргэдэх
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА



ШИЛЭН ДАНС

Байгууллага, аж ахуй нэгж, иргэнд зориулсан **ГАРЫН АВЛАГА**

УТАС: 70324171, 70322625
ФАКС: 70324171
МЭЙЛ: Sankhuu_audit_ov@yahoo.com

WWW.SHILENDANS.GOV.MN

АРВАЙХЭЭР
2021 ОН